



2017 оны 06 дугаар сарын 07  
№21 /978/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Эрүүгийн хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын  
хууль**

**Хог хаягдлын тухай  
/Шинэчилсэн найруулга/**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

314.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	842
315.	Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	870
316.	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/	871
317.	Хог хаягдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	911
318.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	911
319.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	912
320.	Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	912
321.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	913
322.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	913

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

323.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 33	914
------	------------------------------	-----------	-----

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

324.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 75	914
325.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 76	915
326.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 77	915
327.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 78	916
328.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 79	916



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 11-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

#### **1/2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.”

#### **2/2.5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ хуульд заасан “нэгж” гэж энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг ойлгоно.”

#### **3/2.6 дугаар зүйл:**

##### **“2.6 дугаар зүйл.Гэмт хэргийн ангилал**

1.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

2.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.”

#### **4/5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.”

#### **5/5.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, эсхүл

16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно.”

**6/6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Эрүүгийн хариуцлага хүлээж дуусгавар болсон нь хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд хүний эрх зүйн байдлыг дордуулах үндэслэл болохгүй.”

**7/6.15 дугаар зүйл:**

**“6.15 дугаар зүйл.Гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх**

1.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, эсхүл хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийг илрүүлэхэд бодитой тусалсан хамтран ажиллах этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

2.Энэ хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг хамтран ажиллах этгээдээр тооцохгүй.”

**8/7.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөхөө илэрхийлж тэнсэгдсэн хүн хохирлоо нөхөн төлөх хугацааг шүүх тогтооно.”

**9/7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.”

**10/7.6 дугаар зүйл:**

**“7.6 дугаар зүйл.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах**

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

2.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.



3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

4.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.”

#### **11/8.6 дугаар зүйл:**

#### **“8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах**

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

2.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.”

#### **12/9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан хуулийн этгээдийн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

#### **13/9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:

2.1.эрх хасах албадлагын арга хэмжээ;

2.2.татан буулгах албадлагын арга хэмжээ;

2.3.хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.”

**14/9.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно.”

**15/9.6 дугаар зүйл:**

**“9.6 дугаар зүйл.Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ**

1.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

2.Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

**16/9.7 дугаар зүйл:**

**“9.7 дугаар зүйл.Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх**

1.Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол доор дурдсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ:

1.1.бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;

1.2.бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;

1.3.хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;

1.4.хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;

1.5.компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид.



2.Хэргийг хянан шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор санаатайгаар татан буулгасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд, үндэслэлгүйгээр аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээд, эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлсэн бусад хуулийн этгээдээс нөхөн гаргуулна.

3.Хуулийн этгээдэд энэ зүйлийн 1.3-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах боломжгүй, шударга ёсны зарчимд нийцэхгүй бол шүүгч гэмт хэрэг үйлдэгдэх үед тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4.Энэ зүйлд заасан хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн гэмт хэргийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

#### **17/13.8 дугаар зүйлийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ бүлэгт заасан “эрх бүхий албан тушаалтан” гэж хуульд заасны дагуу мөрдөн шалгах, хэрэг бүртгэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий хүнийг ойлгоно.”

#### **18/17.1, 17.4 дүгээр зүйлийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.”

#### **19/18.14 дүгээр зүйл:**

#### **“18.14 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх**

1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл ногдох их хэмжээний орлогыг нуусан, худал мэдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

#### **20/18.15 дугаар зүйл:**

**“18.15 дугаар зүйл.Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах**

1.Зохиомол байдлыг зориудаар бий болгох, бодит байдлыг нуух, даатгалын тохиолдлын бодит байдал, хохирлын хэмжээг худал мэдээлэх, хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар даатгалын нөхөн төлбөр авсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.албан тушаалын байдлаа ашиглаж;

2.2.бүлэглэж;

2.3.их хэмжээний даатгалын нөхөн төлбөр авч үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**21/18.16, 18.17 дугаар зүйл:**

**“18.16 дугаар зүйл.Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих**

1.Бусдын барааны тэмдэг, эсхүл газар зүйн заалтыг ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулан хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой үйлдсэн;

2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.





### **18.17 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих**

1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчиж бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогч, эрх эзэмшигчид их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой үйлдсэн;

2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **22/22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

### **23/22.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Шүүх” гэсний дараа “энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад” гэж, 3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “үйлдлээрээ” гэсний дараа “санаатай” гэж, 5.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “болно.” гэсний дараа “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна.” гэж, 6.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын “илчилсэн,” гэсний дараа “бусдын үйлдсэн” гэж, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “байдлаар” гэсний дараа “хорих” гэж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “хорих ялын” гэсний дараа “доод хэмжээг хоёр жилээс дээш,” гэж, мөн зүйлийн 1.5 дахь заалтын “тогтоосон” гэсний дараа “ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй” гэж, 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төгрөгөөр,” гэсний дараа “нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагаар,” гэж, 17.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, 17.4 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт, 17.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ноцтой,” гэсний дараа “эсхүл” гэж, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ” гэсний дараа “зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан” гэж, 20.12 дугаар

зүйлийн 1 дэх хэсгийн “хүнсний” гэсний дараа “, эсхүл хүнсний нэмэлт” гэж, 21.6 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “өмгөөлөгч,” гэсний дараа “мөрдөгч,” гэж, 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “оногдуулах” гэсний дараа “, ялгаварлах” гэж, 21.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгч,” гэсний дараа “эсхүл” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор,” гэсний дараа “эсхүл” гэж, 22.5 дугаар зүйлийн тайлбарын “хийлгэхээр” гэсний дараа “урьдчилан төлөвлөж, зориуд санаатайгаар” гэж, 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “материалыг” гэсний дараа “бэлтгэсэн,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1. Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.”

**2/1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ.

4. Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.”

**3/1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх заалт:**

“1.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

1.2. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

1.3. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;



1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн.”

#### **4/2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно.”

#### **5/2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдоно.”

#### **6/2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Энэ хуульд заасан дараах хохирлын хэмжээг доор дурдсанаар ойлгоно:

4.1.“их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

4.2.“үлэмж хэмжээний хохирол” гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг;

4.3.“бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг.

#### **7/2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Энэ хуульд гурван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт бэлтгэсэн үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.”

#### **8/2.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:**

“3.Гэмт хэргийг үйлдэж төгсгөх боломжтойг ойлгож байсан боловч туйлд нь хүргэхээс сайн дураараа татгалзсан хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

4.Гэмт хэргээ туйлд нь хүргэхээс сайн дураараа татгалзахаас өмнө хийсэн үйлдэл, эс үйлдэхүй нь бие даасан өөр гэмт хэргийн шинжтэй байвал тухайн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

#### **9/5.1 дүгээр зүйл:**

### **“5.1 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлагын зорилго**

1. Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.

2. Эрүүгийн хариуцлага нь энэ хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.

3. Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна.

4. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5. Хуулийн этгээдэд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”

#### **10/5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.”

#### **11/5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.”

#### **12/6.6 дугаар зүйлийн 1.2 дахь заалт:**

“1.2. энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;”

#### **13/6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5. Шүүх хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн хүний хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан хохирол нөхөн төлөх хугацааг тэнссэн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.”

#### **14/6.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**



“2.Хэд хэдэн гэмт хэрэгт хэд хэдэн төрлийн ял оногдуулсан бол доор дурдсанаар хөнгөн ялыг хүндэд нь нэмж нэгтгэх, эсхүл тус тусад нь эдлүүлэхээр шийдвэрлэж болно:

2.1.торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг;

- 2.2.нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийг;
- 2.3.зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногийг;
- 2.4.хорих ялын нэг хоногийг.”

#### **15/7.1 дүгээр зүйлийн 1, 5, 8 дахь хэсэг:**

“1.Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.

5.Тэнссэн хугацаанд энэ хуулийн тусгай ангид заасан санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож, энэ хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулна.

8.Тэнсэх хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ял оногдуулахгүй.”

#### **16/7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.”

#### **17/8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно.”

#### **18/9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

**19/10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүнийг алсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**20/10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь насыг хохироосон бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**21/11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**22/11.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүний бие махбодид удаан хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулж хөдөлмөрийн чадварын гуравны нэгээс дээшгүйг алдагдуулсан гэмтэл болгоомжгүй учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

**23/13.4 дүгээр зүйл:****“13.4 дүгээр зүйл.Хүнийг хүчээр алга болгох**

1.Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан



талаархи мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### 3.Энэ гэмт хэргийг:

- 3.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;
- 3.2.хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### 4.Энэ гэмт хэргийг:

- 4.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;
- 4.2.хохилогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

## **24/14.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Шашны байгууллага, шашны төлөөлөгч, номлол түгээгч өөрийн шашны үзэл номлолоо бусдад хүчээр тулгасан, шахалт үзүүлсэн, хууран мэхэлж татан оруулсан, эсхүл шашны харгис үзэл номлолыг сурталчилсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

## **25/15.1 дүгээр зүйл:**

### **“15.1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх**

1.Эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүйгээс, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйгээс хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **26/15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Бага насны хүүхэд, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, бэртэл гэмтэлтэй, өвчний улмаас бусдын туслалцаа, асрамж шаардлагатай хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирсан нөхцөлд хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, эсхүл харилцан итгэлцлээр хүлээсэн тусламж үзүүлэх, асран хамгаалах үүргээ зориуд биелүүлээгүй орхисны улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **27/15.3 дугаар зүйл:**

##### **“15.3 дугаар зүйл.Хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах**

1.Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний цусыг авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний эд, эрхтнийг авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **28/16.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөж тэнүүчлэхэд хүргэсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”



**29/16.7 дугаар зүйл:****“16.7 дугаар зүйл.Хүүхэдтэй хэрцгий харьцах**

1.Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

**30/17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**31/17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**32/17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл

зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **33/17.5 дугаар зүйл:**

#### **“17.5 дугаар зүйл.Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших**

1.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **34/17.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:**

“1.Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Нийтийн эзэмшлийн зам харилцаа, цахилгаан, дулаан, холбоо, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **35/17.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Бусдын эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**36/17.11 дүгээр зүйл:****“17.11 дүгээр зүйл.Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх**

1.Нийтийн эзэмшлийн зам харилцаа, цахилгаан, дулаан, холбоо, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг болгоомжгүйгээр устгасан, гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

**37/17.12 дугаар зүйл:****“17.12 дугаар зүйл.Мал хулгайлах**

1.Бусдын малыг хулгайлсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Бусдын олон тооны малыг хулгайлсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “мал” гэдэгт хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ хамаарна.

-Энэ зүйлд заасан “олон тооны мал” гэж хорин дөрвөн бог, найман бодоос дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг гурван богоор тооцно.”

**38/18.3 дугаар зүйл:****“18.3 дугаар зүйл.Татвар төлөхөөс зайлсхийх**

1.Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

#### **39/18.4 дүгээр зүйл:**

#### **“18.4 дүгээр зүйл.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих**

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээгээр хамгаалагдсан бүтээлийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **2.Энэ гэмт хэргийг:**

2.1.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;

2.2.байнга тогтвортой үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **40/18.13 дугаар зүйл:**

#### **“18.13 дугаар зүйл.Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах**

1.Банкыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нээж үйл ажиллагаа явуулсан, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг хууль бусаар бүрдүүлсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Банкны удирдлагын эрх бүхий албан тушаалтан шунахайн, эсхүл хувийн ашиг сонирхлын үүднээс хуулиар тогтоосон банкны төлбөрийн чадвар, банкны өөрийн хөрөнгөтэй холбоотой шаардлагыг



хангуулаагүйгээс банкыг төлбөрийн чадваргүй болгосон, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас бусдад гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлд заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

#### **41/21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **42/22.1 дүгээр зүйл:**

##### **“22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах**

1.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **43/22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан, албаны чиг үүрэг, бүрэн эрхээ албаны эрх ашигт харшаар ашиглаж өөртөө, бусдад давуу байдал бий болгосны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **44/22.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг:**

“1.Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**45/22.9 дүгээр зүйл:****“22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах**

- 1.Нийтийн албан тушаалтан төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг:
  - 1.1.зориулалтын бусаар зарцуулсан;
  - 1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан;
  - 1.3.зохиомол хомсдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;
  - 1.4.төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах, эсхүл сонгогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**46/22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**47/27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зөвшөөрөлгүй арилжааны нислэг үйлдсэн, заасан маршрутыг зөрчиж ниссэн, агаарын зам, буух газрыг дур мэдэн өөрчилсөн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**48/27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

**4 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ял, албадлагын арга хэмжээг” гэснийг “түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн гарчгийн “ялын” гэснийг “эрүүгийн хариуцлагын” гэж, 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Ял, албадлагын арга хэмжээг” гэснийг “Эрүүгийн хариуцлагыг” гэж, 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 1.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 1.6 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, 2.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна” гэснийг “хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж, 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “үйлдэл, эс үйлдэхүйд ял оногдуулахгүй, албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж, 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Дипломат” гэснийг “Гадаад улсын дипломат” гэж, мөн хэсгийн “ял оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэж, 1.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулна.” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулаагүй, албадлагын арга хэмжээ хэрэглээгүй” гэснийг “нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй” гэж, 1.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 4.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28.4 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг, 28.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж, 4.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 28.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Цэргийн албан” гэснийг “Цэргийн алба” гэж, 1.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “ял оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэж болно.” гэж, 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тооцох ба оногдуулах ялын” гэснийг “тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын” гэж, 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мэдсэн атлаа” гэснийг “ухамсарлаж” гэж, 2.6 дугаар зүйлийн дугаарыг “2.7” гэж, 2.7 дугаар зүйлийн дугаарыг “2.8” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ГЭМТ ХЭРЭГ ХАМТРАН ҮЙЛДЭХ” гэснийг “ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ” гэж, 3.1 дүгээр зүйлийн гарчгийн “Гэмт хэрэг хамтран үйлдэх” гэснийг “Гэмт хэрэгт хамтран оролцох” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “гэмт хэрэг хамтран үйлдэх” гэснийг “гэмт хэрэгт





хамтран оролцох” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “гэмт хэрэг хамтран үйлдэгчид” гэснийг “гэмт хэрэгт хамтран оролцогчид” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “гэмт хэрэг хамтран үйлдсэнд” гэснийг “гэмт хэрэгт хамтран оролцсонд” гэж, 4.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хууль зүйн” гэснийг “хуулийн” гэж, Тавдугаар бүлгийн гарчгийн “ЯЛЫН” гэснийг “ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН” гэж, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэгжтэй” гэснийг “торгуулийн нэгж /цаашид “нэгж” гэх/-тэй” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “хоёр” гэснийг “нэг” гэж, 5.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “хүн,” гэснийг “хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг” гэж, 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “долоо хоногоос” гэснийг “зургаан сараас” гэж, Зургадугаар бүлгийн гарчиг, Наймдугаар бүлгийн гарчиг, Есдүгээр бүлгийн гарчгийн “ЯЛ ОНОГДУУЛАХ” гэснийг “ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ” гэж, 6.1 дүгээр зүйлийн гарчиг, 6.2 дугаар зүйлийн гарчгийн “Ял оногдуулах” гэснийг “Эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэж, 8.1 дүгээр зүйлийн гарчиг, 9.1 дүгээр зүйлийн гарчгийн “ял оногдуулах” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэж, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ял оногдуулахад” гэснийг “Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд” гэж, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ялыг” гэснийг “эрүүгийн хариуцлагыг” гэж, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Ял, албадлагын арга хэмжээ” гэснийг “Эрүүгийн хариуцлага” гэж, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ялаас” гэснийг “эрүүгийн хариуцлагаас” гэж, 6.5 дугаар зүйлийн гарчиг, 6.6 дугаар зүйлийн гарчгийн “Ял” гэснийг “Эрүүгийн хариуцлагыг” гэж, 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулахдаа” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ” гэж, 6.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ялыг хүндрүүлж оногдуулахыг” гэснийг “эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг” гэж, 6.7 дугаар зүйлийн гарчгийг “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” гэж, мөн зүйлийн 1.1, 1.2 дахь заалтын “илэрхийлж хохирогчтой эвлэрсэн” гэснийг “илэрхийлсэн” гэж, мөн зүйлийн 1.2 дахь заалтын “таван жил хүртэл” гэснийг “таван жил, түүнээс бага” гэж, мөн зүйлийн 1.3, 1.4, 1.5 дахь заалтын “төлж, хохирогчтой эвлэрсэн” гэснийг “төлсөн” гэж, 6.8 дугаар зүйлийн гарчгийг “Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах” гэж, 7.1 дүгээр зүйлийн гарчгийг “Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх” гэж, 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг” гэснийг “эмгэгийг” гэж, 7.5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “хүний” гэснийг “хүн, хуулийн этгээдийн” гэж, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “оногдуулах ял” гэснийг “хүлээлгэх эрүүгийн хариуцлага” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон” гэснийг “Хүнд” гэж, 8.6 дугаар зүйлийн дугаарыг “8.7” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Энэ хуулийн тусгай ангид найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан” гэснийг “Хөнгөн” гэж, 9.1 дүгээр зүйлийн 2

дахь хэсгийн “хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн” гэснийг “хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй” гэж, 9.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “ял,” гэснийг “ял.” гэж, 9.4, 9.5 дугаар зүйлийн гарчгийн “ял” гэснийг “албадлагын арга хэмжээ” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “хуульд” гэснийг “хуулийн тусгай ангид” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсэг, 9.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулна.” гэснийг “албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэж, 10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “сэтгэцийн” гэснийг “сэтгэл санааны” гэж, 10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт, 12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2.2 дахь заалт, 13.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19.15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 21.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 23.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, 28.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 28.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 29.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас” гэснийг “зургаан сараас” гэж, 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 11.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 13.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 25.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 13.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 27.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 27.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 11.6 дугаар



зүйлийн 2 дахь хэсгийн “нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг зуун нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 17.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 12.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 12.3 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “хүүхдийг” гэснийг “хүнийг” гэж, 12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гурван сараас” гэснийг “зургаан сараас” гэж, 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг” гэснийг “Хохирогчид” гэж, 13.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг зуун нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 13.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 13.6 дугаар зүйлийн гарчгийн “Хүний” гэснийг “Бусдын” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 13.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,

21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 14.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 20.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг зуун нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл долоо хоногоос гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг зуун нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоо хоногоос зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 13.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Эрх” гэснийг “Энэ гэмт хэргийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл эрх” гэж, 13.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хүн, түүний” гэснийг “хүний бие, хүний” гэж, 13.8 дугаар зүйлийн гарчгийн “хийх” гэснийг “хийж дамжуулах, тараах” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “хийсэн” гэснийг “хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан” гэж, 13.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хувь хүн нууцалж хамгаалсан, олон нийтэд ил болгоогүй баримт, мэдээллийг өөрийнх нь, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр” гэснийг “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг хууль бусаар” гэж, 13.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Хувь хүн нууцалж, хамгаалсан баримт, мэдээллийг” гэснийг “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг” гэж, 13.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хохирогчид” гэснийг “Бусдад” гэж, 13.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг, 18.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх,



эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 15.2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “арван мянган нэгжээс дөчин мянган” гэснийг “таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган” гэж, мөн заалтын “хоёр жилээс найман” гэснийг “нэг жилээс таван” гэж, 15.6 дугаар зүйлийн “эрүүл мэндэд” гэснийг “амь насанд” гэж, 16.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “арван хоёр жилээс хорин” гэснийг “таван жилээс арван хоёр” гэж, 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гурван сараас хоёр” гэснийг “зургаан сараас таван” гэж, мөн зүйлийн 3.3 дахь заалтын “найман жилээс арван таван” гэснийг “таван жилээс арван хоёр” гэж, 18.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дамжуулсны улмаас үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид их хэмжээний хохирол учруулсан” гэснийг “дамжуулсан” гэж, 18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ашиглаж бусдад их хэмжээний хохирол учруулсан” гэснийг “ашигласан” гэж, 19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “захиргааны хэм хэмжээний акт” гэснийг “журам” гэж, 19.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хуурах,” гэснийг “Хуурамч” гэж, мөн хэсгийн “Монгол Улсын харьяалал” гэснийг “Монгол Улсын иргэний харьяалал” гэж, 19.16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зориуд” гэснийг “хууль бусаар” гэж, 20.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэснийг “таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр үүрэг хүлээсэн хүн, эсхүл нийтийн албан тушаалтанд” гэснийг “бусдад” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эрхийг хоёр” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “эрхийг гурван” гэснийг “эрхийг хоёр жилээс таван” гэж, мөн

зүйлийн тайлбарын “хаагчийн” гэснийг “тушаалтны” гэж, “албан үүргээ” гэснийг “албаны чиг үүргээ” гэж, 22.8 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “эд хөрөнгө” гэснийг “бараа, ажил, үйлчилгээ” гэж, 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “албан хаагч” гэснийг “албан тушаалтан” гэж, 18.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 20.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 23.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 25.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин” гэснийг “хоёр мянга долоон зуун” гэж, 18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нэг мянга гурван зуун тавин” гэснийг “хоёр мянга долоон зуун” гэж, 24.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “байгалийн тэнцлийг алдагдуулсан” гэснийг “экологийн тогтолцоог алдагдуулсан” гэж, 28.7 дугаар зүйлийн гарчгийн “хэрэгслийг” гэснийг “хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг” гэж, 28.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нэг сараас зургаан сар” гэснийг, 28.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “долоо хоногоос гурван сар” гэснийг “зургаан сараас нэг жил” гэж, 29.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 29.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “татан буулгах ял шийтгэнэ” гэснийг “албадан татан буулгана” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн тайлбарын “тахар,” гэснийг, 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулж болзошгүй” гэснийг, 6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “оногдуулж” гэснийг, 7.3 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “нийтэд тустай” гэснийг, 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн өөртөө, бусдад аюул учруулж болзошгүй” гэснийг, 11.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гэмт хэргийг согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн; энэ” гэснийг, 11.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж” гэснийг, 11.6 дугаар зүйлийн гарчгийн “санаатай халдах,” гэснийг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “санаатай халдсан, эсхүл” гэснийг, 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “, эсхүл тодорхой үйлдэл, эс үйлдэхүй шаардсан” гэснийг, 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл” гэснийг, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл” гэснийг, 20.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн” гэснийг, 21.6 дугаар зүйлийн 1 дэх



хэсгийн “, шан харамж амласан, өгсөн” гэснийг, 22.8 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “их хэмжээний” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 7.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, 9.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 12.1 дүгээр зүйлийн 2.9 дэх заалт, 12.4 дүгээр зүйл, 13.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 17.3 дугаар зүйлийн тайлбар, 20.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 20.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 20.7 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, 20.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 21.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 21.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 22.2 дугаар зүйл, 24.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 24.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 11-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмсүгэй:

**“5 дугаар зүйл.** 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан зорчих эрхийг хязгаарлах ялыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн дугаарыг “6” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хог хаягдлын тухай хууль тогтоомж

2.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Байгаль орчныг хамгаалах тухай хууль<sup>2</sup>, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль<sup>3</sup>, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль<sup>4</sup>, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль<sup>5</sup>, Агаарын тухай хууль<sup>6</sup>, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль<sup>7</sup>, Усны тухай хууль<sup>8</sup>, Эрүүл ахуйн тухай хууль<sup>9</sup>, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Агаарын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Усны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup> Эрүүл ахуйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 8 дугаарт нийтлэгдсэн.





ашиглалтын тухай хууль<sup>10</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хуулиар дараахь хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна:

3.1.1.энгийн хатуу хог хаягдал;

3.1.2.цацраг идэвхт хог хаягдлаас бусад хий, шингэн, хатуу төлөвт орших аюултай хог хаягдал.

### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хог хаягдал” гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;

4.1.2.“аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;

4.1.3.“энгийн хог хаягдал” гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;

4.1.4.“ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг;

4.1.5.“овор хэмжээ ихтэй хог хаягдал” гэж 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй хог хаягдлыг;

4.1.6.“нийтийн эзэмшлийн эд хөрөнгө” гэж нийтийн эдэлбэр газар байрлуулсан хашаа, хайс, гэрэлтүүлэг, тэмдгийн шон, хөшөө дурсгал, замын байгууламж, ногоон байгууламжийг;

4.1.7.“хог хаягдал ангилах” гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг;

4.1.8.“хог хаягдал цуглуулах” гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг;

<sup>10</sup>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 41 дугаарт нийтлэгдсэн.



4.1.9. “хог хаягдал хадгалах” гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулахыг;

4.1.10. “хог хаягдал дахин ашиглах” гэж ашиглагдаж байсан зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулахыг;

4.1.11. “хог хаягдал сэргээн ашиглах” гэж хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх, эсхүл нэрэх, цэвэрлэх, сэргээх зэрэг аргаар анхны хэлбэрт оруулж, ашиглахыг;

4.1.12. “хог хаягдал дахин боловсруулах” гэж хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;

4.1.13. “хог хаягдлыг шатаах” гэж хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж, задлахыг;

4.1.14. “хог хаягдлыг булшлах” гэж хог хаягдлыг газарт булж хадгалахыг;

4.1.15. “биологийн боловсруулалт” гэж бичил биетээр бохирдуулагчийг устгах болон хоргүйжүүлэхийг;

4.1.16. “хими-физикийн боловсруулалт” гэж химийн болон физикийн боловсруулалтыг хослуулан хэрэглэхийг;

4.1.17. “химийн боловсруулалт” гэж химийн бодис ашиглаж хоргүйжүүлэхийг;

4.1.18. “физикийн боловсруулалт” гэж шүүх, тунадасжуулах, шингээх, нэрэх зэрэг аргаар бохирдуулагчийг цэвэрлэхийг;

4.1.19. “халдваргүйжүүлэх” гэж химийн болон физикийн аргаар халдвартай бичил биетийг устгахыг;

4.1.20. “хог хаягдлыг устгах” гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг;

4.1.21. “хог хаягдал шатаах зориулалтын байгууламж” гэж хог хаягдлыг өндөр хэмд, хяналттай шатаах төхөөрөмж бүхий байгууламжийг;

4.1.22. “ландфилл” гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг;

4.1.23. “хог хаягдлын төвлөрсөн цэг” гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газрыг;

4.1.24. “аюултай хог хаягдлын дагалдах бичиг” гэж батлагдсан журмын дагуу бөглөж, гарын үсэг зурж, баталгаажуулсан тээврийн баримт бичгийг;

4.1.25. “хог хаягдлын норматив” гэж нэгж үйлдвэрлэл, үйлчилгээ, иргэнээс үүсэх хог хаягдлын тогтоосон хэмжээг;



4.1.26. “хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах” гэж хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой бүтээгдэхүүн импортлох, хэрэглэх болон хог хаягдалгүй эсхүл хамгийн бага хэмжээгээр үүсгэдэг технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;

4.1.27. “дахивар нөөц” гэж дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг;

4.1.28. “хог хаягдлын талаархи боловсрол” гэж хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хог хаягдлын менежментийн арга, технологи болон хог хаягдалтай зохистой харьцах мэдлэг, дадал олгох, албан болон албан бус сургалтын агуулгын түвшинг;

4.1.29. “бүтээгдэхүүний амьдралын мөчлөг” гэж бүтээгдэхүүн материалыг үйлдвэрлэснээс эхлээд устгах хүртэлх хугацааг;

4.1.30. “бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн схем” гэж бүтээгдэхүүний амьдралын мөчлөг дэх үе шат нэг бүрийг харуулсан үгэн болон зурган тайлбарыг;

4.1.31. “хог хаягдлын үйлчилгээний хураамж” гэж хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлын хувь хэмжээг харгалзан тогтоосон татварыг;

4.1.32. “аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс” гэж аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, хадгалах, устгахад шаардагдах зардлын мөнгөн дүнг;

4.1.33. “хог хаягдлыг ил шатаах” гэж хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус байгууламжид шатаахыг;

4.1.34. “хамгийн боломжит арга технологи” гэж хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах хамгийн үр дүнтэй, эдийн засгийн болон технологийн хувьд хэрэгжүүлэх боломжтой арга, техник, технологийг;

4.1.35. “хамгийн боломжит байгаль орчинд ээлтэй арга ажиллагаа” гэж байгаль орчны бодлого болон хяналтыг хамгийн оновчтой байдлаар хослуулан хэрэглэхийг;

4.1.36. “тээврийн хэрэгслийн хог хаягдал” гэж тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ болон ашиглалтаас гарсан тээврийн хэрэгсэл, тэдгээрийг задлахад үүсэх хог хаягдлыг;

4.1.37. “барилгын хог хаягдал” гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг;

4.1.38. “аюултай хог хаягдал үүсгэгч” гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;

4.1.39. “аюултай хог хаягдал хүлээн авагч” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг;

4.1.40. “аюултай хог хаягдал тээвэрлэгч” гэж аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгчийг;

4.1.41. “аюултай хог хаягдал хариуцсан ажилтан” гэж хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажилтныг;

4.1.42. “нийцгүй хог хаягдал” гэж агуулж байгаа саваа идэж гэмтээдэг, эсхүл бусад хог хаягдалтай хольсноос дулаан ялгаруулдаг, даралт нэмэгдүүлдэг, галын болон тэсрэх аюул үүсгэдэг, эрчимтэй урвалд ордог, хортой тоос, утаа, манан, хий болон шатамхай хий, уур үүсгэдэг аюултай хог хаягдлыг;

4.1.43. “аюултай эд анги агуулсан бүтээгдэхүүн” гэж бүтнээрээ байхдаа аюултай шинж чанаргүй боловч, задалж салгасны дараа зарим хэсэг нь аюултай шинж чанартай хог хаягдал үүсгэдэг эд юмсыг;

4.1.44. “аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюултай хог хаягдал асгарах, алдагдах болон тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах, хэрэгжүүлэх, зохицуулах арга хэмжээг төлөвлөж, тодорхойлсон баримт бичгийг;

4.1.45. “онцгой байдлын зохицуулагч” гэж аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах ажилтныг;

4.1.46. “аюултай хог хаягдал алдагдах” гэж аюул, ослын үед аюултай хог хаягдал хөрс, ус руу асгарах, алдагдах, эсвэл зориудаар аюултай хог хаягдлыг хөрс, ус руу хаях, асгах, нийлүүлэх, шахах, ялгаруулахыг;

4.1.47. “бүрэн хаах” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагааг зогсоож, зохих шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүйгээр хаах арга хэмжээ авахыг;

4.1.48. “хэсэгчлэн хаах” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламжийн үйл ажиллагааны нэг хэсгийг зохих шаардлагын дагуу хааж, зарим хэсэг нь уг ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахыг;

4.1.49. “ландфиллд хэсэгчлэн булшлах” гэж аюултай хог хаягдлыг доторлогооны материалаар тусгаарлан хэсэгчлэн хаах үйл ажиллагааг;



4.1.50. “ландфиллын үүр” гэж хэсэгчлэн булшилсан ландфиллын хэсэг эзлэхүүнийг;

4.1.51. “шүүрэл” гэж аюултай хог хаягдлаас ялгарсан шингэнийг;

4.1.52. “чөлөөт шингэн” гэж хэвийн даралт болон температурын үед хаягдлын хатуу хэсгээс салгах боломжтой шингэнийг;

4.1.53. “нийлэг материал” гэж хуванцар, резин зэрэг органик полимер материалыг.

### **5 дугаар зүйл. Хог хаягдлыг өмчлөх эрх**

5.1. Хог хаягдлыг үүсгэгч этгээд өмчлөх эрхтэй.

5.2. Хог хаягдлыг өмчлөх эрх гэрээний үндсэн дээр шилжиж болно.

5.3. Хог хаягдлыг зориулалтын цэгт байршуулснаар өмчлөх эрх дуусгавар болно.

5.4. Энэ хуулийн 5.2, 5.3-т заасны дагуу өмчлөх эрх шилжсэнээр хог хаягдлыг өмчлөх тухайн этгээдийн эрх дуусгавар болж, хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, хадгалах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөх эрх үүснэ.

5.5. Аюултай хог хаягдлыг өмчлөгч нь өмчлөх эрхээ шилжүүлсэн бол энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, аюултай хог хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Хог хаягдлын талаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

6.1.2. Засгийн газраас өргөн мэдүүлснээр хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;



6.1.3.хууль тогтоомжид заасан бусад.

### **7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Хог хаягдлын талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах;

7.1.2.аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам батлах;

7.1.3.аюултай хог хаягдлын жагсаалт батлах;

7.1.4.Монгол Улсад импортлохыг хязгаарласан болон хориглосон зарим хог хаягдлын жагсаалт батлах;

7.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

### **8 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1.Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах;

8.1.2.хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах;

8.1.3.хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журмыг батлах;

8.1.4.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох;

8.1.5.энэ хуулийн 8.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журмыг батлах;

8.1.6.эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг батлах;

8.1.7.дараахь маягыг батлах:

8.1.7.а.аюултай хог хаягдлын дагалдах бичгийн;

8.1.7.б.аюултай хог хаягдлын үүсгэгч болон



тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх;

8.1.7.в.энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх;

8.1.7.г.аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны тайлангийн;

8.1.7.д.энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн.

8.1.8.энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагыг батлах;

8.1.9.дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх:

8.1.9.а.аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх;

8.1.9.б.энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх;

8.1.10.энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалыг батлах;

8.1.11.хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан зааврыг батлах;

8.1.12.хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах;

8.1.13.дахин боловсруулах боломжтой түүхий эд болон дахивар нөөцөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний таних тэмдгийн стандартыг эрх бүхий байгууллагаар батлуулах;

8.1.14.үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.

8.2.Хог хаягдлын талаар зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.2.1.тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.2.2.энэ хуулийн 8.1.10-т заасан аргачлалын дагуу барилгын хог хаягдлын норматив хэмжээг тогтоох;

8.2.3.барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

8.2.4.олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж, төмөр замын зурвас газрын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих.

8.3.Хог хаягдлын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1.харьяа нэгж, байгууллагынхаа хог хаягдлын менежментийг хариуцаж хяналт тавих, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

8.3.2.эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам, аргачлал, зааврыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.3.3.эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлалыг батлах;

8.3.4.энэ хуулийн 8.1.10-т заасан аргачлалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын норматив хэмжээг тогтоох;

8.3.5.эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

8.4.Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1.энэ хуулийн 8.3.1-д заасан бүрэн эрх;

8.4.2.сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хог хаягдлын талаархи боловсролын агуулгыг тусгах;

8.4.3.энэ хуулийн 8.1.10-т заасан аргачлалын дагуу боловсролын байгууллагын энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох;

8.4.4.хог хаягдалтай холбоотой үүссэн бохирдлыг тогтоох, цэвэрлэх, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах арга, технологийн талаар судалгаа хийх, дэвшилтэт технологи, арга зүйн талаар зөвлөмж боловсруулах.





8.5.Хог хаягдлын талаар батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.5.1.харьяа нэгж, байгууллагад үүссэн болон цэргийн зориулалтаар ашиглаж байсан газарт үлдсэн галт зэвсэг, сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, тэдгээрийн үлдэгдлийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.5.2.энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх.

8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.6.1.уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

8.6.2.уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.6.3.энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүссэн хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх.

8.7.Хог хаягдлын талаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.7.1.хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах;

8.7.2.энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

8.7.3.хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бодлого боловсруулах.

8.8.Хог хаягдлын талаар эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрчим хүчний зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



8.8.1.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

8.8.2.хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаанаас гарган авсан эрчим хүчний үнийн тооцоог хянах, тарифыг батлах.

### **9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх**

9.1. Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.2. хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих;

9.1.3. энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;

9.1.4. энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах;

9.1.5. энэ хуулийн 40.4-т заасан урамшуулал олгох журмыг батлах.

9.2. Хог хаягдлын талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 9.1.1-д зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1. энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах;

9.2.2. энэ хуулийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох.

9.3. Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1. хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

9.3.2. энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;



9.3.3.энэ хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл олгох журмыг батлах;

9.3.4.хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах;

9.3.5.энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх;

9.3.6.хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

9.3.7.нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих;

9.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар байгуулсан хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай<sup>11</sup> хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

9.3.9.хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

9.3.10.хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан эсхүл болзошгүй аюул үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тархалтыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах;

9.3.11.нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх;

9.3.12.хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг батлах;

9.3.13.хууль тогтоомжид заасан бусад.

9.4.Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

<sup>11</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2005 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

9.4.2.энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

9.4.3.нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.4.2-т заасны дагуу зохион байгуулах;

9.4.4.хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуулийн 41.9-д заасны дагуу зарцуулах;

9.4.5.нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх;

9.4.6.энэ хуулийн 42.3, 42.4-т заасан хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

9.4.7.хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах;

9.4.8.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;

9.4.9.хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

9.4.10.энэ хуулийн 9.5.7-д заасан иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

9.4.11.нийтийн эдэлбэр газарт хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах;

9.4.12.нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;

9.4.13.энэ хуулийн 9.3.11-д заасан эрхийг хэрэгжүүлэх;

9.4.14.энэ хуулийн 9.3.12-т заасан журмын дагуу ажиллах хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавих.

9.5.Хог хаягдлын талаар баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.5.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

9.5.2.хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;



9.5.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;

9.5.4.хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

9.5.5.хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

9.5.6.хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;

9.5.7.хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах.

## **10 дугаар зүйл.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

10.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлнэ:

10.1.1.хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;

10.1.2.хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

10.2.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;

10.2.2.энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;

10.2.3.аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

10.2.4.хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

10.2.5.үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;

10.2.6.нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;

10.2.7.хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;

10.2.8.хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;

10.2.9.эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;

10.2.10.энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;

10.2.11.барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

10.2.12.хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;

10.2.13.хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;

10.2.14.хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;

10.2.15.хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;

10.2.16.аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

10.2.17.үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

10.2.18.аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.



10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:

10.3.1.хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;

10.3.2.нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;

10.3.3.хог хаягдлыг ил задгай шатаах;

10.3.4.гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;

10.3.5.хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

10.3.6.аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;

10.3.7.нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТ**

#### **11 дүгээр зүйл.Мэдээллийн нэгдсэн сан**

11.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хог хаягдлын мэдээллийн нэгдсэн сантай, аймаг, нийслэл, сум, дүүрэг хог хаягдлын мэдээллийн дэд сантай байна.

11.2.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэлийн дугаар олгож, мэдээллийн санд бүртгэнэ.

11.3.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

11.4.Сум, дүүрэг энгийн хог хаягдлын мэдээг аймаг нийслэлд, аймаг нийслэл хог хаягдлын нэгдсэн мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

11.5.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг энэ хуулийн 8.1.3-т заасан журмаар зохицуулна.

### **12 дугаар зүйл.Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл**

12.1.Энэ хуулийн 8.1.12-т заасан орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах ба дараахь үүрэгтэй:

12.1.1.хог хаягдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах;

12.1.2.энэ хуулийн 8.1.4-т заасан зөвшөөрөлтэй холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргах.

### **13 дугаар зүйл.Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагаанд тавих хяналт**

13.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд улсын мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан хяналт тавина.

13.2.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина.

13.3.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ**

#### **14 дүгээр зүйл.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх**

14.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.

14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.





14.4.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.

14.6.Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

14.7.Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

14.8.Энэ хуулийн 14.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

#### **15 дугаар зүйл.Хогийн саванд тавигдах шаардлага**

15.1.Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараахь шаардлагыг хангасан байна:

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

#### **16 дугаар зүйл.Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах**

16.1.Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.

16.2.Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаанд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулсан байна.

16.3.Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлага болон орон нутгийн онцгой байдлын газраар батлуулсан байна.

16.4.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэм боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулсан байна.

16.5.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн ажилтан тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамрагдаж, шалгалтанд тэнцсэн байна.

16.6.Сэргээн ашигласан, дахин боловсруулсан, устгасан, булшилсан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлнэ.

16.7.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн байршлыг хэд хэдэн аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран тогтоож болно.

16.8.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулахыг хориглоно.

16.9.Хог хаягдлыг сэргээн ашиглаж дулаан, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө.

### **17 дугаар зүйл.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн ерөнхий шаардлага**

17.1.Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах байгууламж дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:

17.1.1.байгууламжид зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал, амьтан орохоос хамгаалсан хашаатай;

17.1.2.харуул хамгаалалт, дохиоллын системтэй;

17.1.3.хэмжих хэрэгсэл бүхий бүртгэлийн байртай;

17.1.4.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хяналтын системтэй;

17.1.5.хяналтын камертай;

17.1.6.хог хаягдлын бүтэц найрлагыг тогтоох тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан;

17.1.7.галын аюулгүй байдлын дохиолол, хамгааллын системтэй;

17.1.8.үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол гарсан үед мэдрэх хяналтын системтэй;

17.1.9.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжтэй;



17.1.10.үйл ажиллагаанаас үүсэх агаар, хөрс, усанд ялгарах ялгарлыг хянах системтэй;

17.1.11.төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбогдсон эсхүл хэсэгчилсэн инженерийн байгууламжтай.

17.2.Хог хаягдлын төвлөрсөн цэгийг ландфиллын бүтэц, булшлах технологиос хамааруулж гурван зэрэглэлээр ангилна.

17.3.Нэг, хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфиллд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

17.4.Нэгдүгээр зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэг дараахь нэмэлт шаардлагыг хангасан байна:

17.4.1.төвлөрсөн хогийн цэг болон ландфиллыг батлагдсан зураг, стандартын дагуу байгуулах;

17.4.2.шүүрлийг цуглуулах, хуримтлуулах, цэвэршүүлэх системтэй;

17.4.3.хог хаягдлын ялзралаас үүсэх хийг зайлуулах, хуримтлуулах системтэй;

17.4.4.газрын доорхи усны хяналт-шинжилгээний худагтай;

17.4.5.үерийн хамгаалалтын далан, хур борооны ус зайлуулах системтэй;

17.4.6.хог хаягдлын хучилтын хөрс нөөцлөх талбайтай;

17.4.7.ландфиллын үйл ажиллагаанд шаардлагатай машин механизм, техник, тоног төхөөрөмжтэй;

17.4.8.хамгаалалтын бүс нь орон сууц, олон нийтийн бүсээс 300 метрээс багагүй зайд;

17.4.9.ландфиллын суурь нь шүүрэл нэвчихээс хамгаалсан доторлогоотой;

17.4.10.хог хаягдал тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг цэвэрлэх нөхцөлөөр хангагдсан.

17.5.Хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэг дараахь нэмэлт шаардлагыг хангасан байна:

17.5.1.энэ хуулийн 17.4.1, 17.4.4, 17.4.6-17.4.8-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байх;

17.5.2.шүүрлийг цуглуулах, хуримтлуулах системтэй;



17.5.3.хог хаягдлын ялзралаас үүсэх хийг зайлуулах хоолойтой;

17.5.4.үерийн хамгаалалтын далан, хур борооны ус зайлуулах сувагтай.

17.6.Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэг дараахь шаардлагыг хангасан байна:

17.6.1.хог хаягдлыг дарж булшлах талбай нь газрын гадаргаас доош түвшинд байрласан;

17.6.2.хог хаягдлыг тархахаас хамгаалсан хашаа эсхүл зөөврийн торон хаалттай;

17.6.3.хог хаягдлыг түрж нягтруулах техник хэрэгсэлтэй.

17.7.Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанаас ялгарах ялгарлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг стандартаар тогтооно.

### **18 дугаар зүйл.Төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах**

18.1.Төвлөрсөн цэгт хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг энэ хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

18.2.Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт дараахь үйл ажиллагааг явуулна:

18.2.1.хог хаягдлыг шалгаж, хэмжиж, бүртгэж хүлээж авах;

18.2.2.хог хаягдлыг тархахаас сэргийлж хөрсөөр дарж нягтруулах;

18.2.3.ландфиллын бүрэн бүтэн байдал болон шүүрлийн систем, хий зайлуулах систем, машин техникийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих;

18.2.4.хөрс, агаар, усны хяналт-шинжилгээний төлөвлөгөөтэй байх;

18.2.5.булшилсан хог хаягдлын хэмжээ бүтцийн талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.

18.3.Гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт дараахь үйл ажиллагааг явуулна:

18.3.1.хог хаягдлыг шалгаж, бүртгэж хүлээж авах;



18.3.2. хог хаягдлыг тархахаас сэргийлж бөөгнөрүүлэн дарж нягтруулах;

18.3.3. машин техникийн хэвийн үйл ажиллагааг хангах.

### **19 дүгээр зүйл. Ландфиллыг хаах**

19.1. Ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хааж болно.

19.2. Ландфиллын хучилтын давхарга нь тогтвортой, гулсалт, нуралт үүсэхгүй, элэгдэл, эвдрэлд хамгийн бага орохоор төлөвлөгдөж хийгдсэн байна.

19.3. Ландфиллыг хаах болон хаасны дараахь хяналт-шинжилгээ, арчилгаа үйлчилгээг ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл гэрээ байгуулсан байгууллага гүйцэтгэнэ.

19.4. Энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагаанд шаардагдах зардлыг ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

19.5. Ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хаах үйл ажиллагаанд тухайн орон нутгийн эрх бүхий мэргэжлийн хяналтын байцаагч хяналт тавина.

### **20 дугаар зүйл. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хориглох**

#### **үйл ажиллагаа**

20.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараахь хог хаягдал булшлахыг хориглоно:

20.1.1. аюултай хог хаягдал;

20.1.2. халдвартай хог хаягдал;

20.1.3. шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал.

20.2. Хог хаягдал шатаахыг хориглоно.

20.3. Зөвшөөрөлгүй иргэн болон мал, амьтныг хог хаягдлыг хүлээж авах, булшлах талбайд оруулахыг хориглоно.

20.4. Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

20.5. Хаагдсан ландфиллын газарт барилга барих, суурьшлын бүс байгуулахыг хориглоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ САВЛАХ, ТҮР ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ

#### 21 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх

21.1. Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.

#### 22 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг савлах

22.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална.

22.2. Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.

#### 23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах

23.1. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараахь хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно:

23.1.1. сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;

23.1.2. сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.

23.2. Тодорхой шалтгааны улмаас энэ хуулийн 23.1-д заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.

23.3. Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.

23.4. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.



23.5.Аюултай хог хаягдлыг хадгалах үед үүссэн шүүрлийг аюултай хог хаягдал гэж үзнэ.

23.6.Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг энэ хуулийн 8.1.4-т заасан зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхэд энэ хуулийн 8.1.7.а-д заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлнэ.

23.7.Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.

#### **24 дүгээр зүйл.Аюултай хог хаягдлыг тээвэрлэх**

24.1.Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

24.2.Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал үүсгэгчээс тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичигтэй аюултай хог хаягдлыг гэрээний үндсэн дээр хүлээн авч тээвэрлэнэ.

24.3.Аюултай хог хаягдал тээвэрлэгч хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж хүлээн авна.

24.4.Аюултай хог хаягдал тээвэрлэгч хог хаягдлын дагалдах бичгийг хүлээн авагчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.

24.5.Аюултай хог хаягдал тээвэрлэгч тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал болон аюултай хог хаягдлын сав баглаа боодол, тоо хэмжээний бүрэн бүтэн байдлыг хариуцна.

24.6.Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар тээврийн хэрэгслийг хангасан байна.

24.7.Аюултай хог хаягдал үүсгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээнд үл зохицол үүсвэл аюултай хог хаягдал хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно.

24.8.Энэ хуулийн 24.7-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хог хаягдлыг аюултай хог хаягдал үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг тухайн аюултай хог хаягдал үүсгэгч хариуцна.

24.9.Тээвэрлэлтийг нэгээс дээш аюултай хог хаягдал тээвэрлэгч гүйцэтгэвэл эцсийн тээвэрлэгчээс бусад тээвэрлэгчид хог хаягдлын дагалдах бичгийн хуулбарыг хадгална.

24.10.Нийцгүй аюултай хог хаягдлыг хамт тээвэрлэхийг хориглоно.

24.11.Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэл,

стандартад заасан анхааруулах тэмдэг байрлуулсан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх ба аюултай хог хаягдлыг ачих, буулгах, тээвэрлэхэд энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг мөрдөнө.

24.12.Аюултай хог хаягдал тээвэрлэгч нь аюултай хог хаягдал тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг цэвэрлэх, ариутгах байгууламжтай байна.

24.13.Тээвэрлэлтийн үед аюултай хог хаягдал асгарсан тохиолдолд аюултай хог хаягдал үүсгэгч болон тухайн орон нутгийн онцгой байдлын албанд мэдэгдэнэ.

### **25 дугаар зүйл.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгахад тавигдах шаардлага**

25.1.Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийг дараахь байршилд байгуулахыг хориглоно:

25.1.1.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд;

25.1.2.хүн амын унд, ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн дотор;

25.1.3.хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэр болон гадаргын уснаас хоёр километрээс бага зайд;

25.1.4.үерийн усны урсац дайран өнгөрөх зам, талбайд;

25.1.5.ус, намгархаг газарт;

25.1.6.нефть, нүүрс болон байгалийн хийн нөөц бүхий газарт;

25.1.7.шохойн чулуу болон 50 ба түүнээс дээш хувийн карбонатын эрдэс агуулсан үндсэн чулуулагтай газарт;

25.1.8.улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт;

25.1.9.төмс, хүнсний ногоо, тариалангийн талбайгаас нэг километрээс бага зайд;

25.1.10.орон сууц, олон нийтийн бүс болон зэргэлдээх барилга, байгууламжаас нэг километрээс бага зайд.

25.2.Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийн гадаад хил буюу гадаад орчноос тусгаарласан хашаанаас энэ хуулийн 25.1-д заасан зайг тооцно.

25.3.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламж дараахь шаардлагыг хангасан байна:





25.3.1.нэг хувийн чийгийн хангамшилтай жилийн үерийн урсацын хэмжээнд тооцсон үерийн хамгаалалтын барилга байгууламжтай;

25.3.2.нэг хувийн чийгийн хангамшилтай жилийн үерийн урсацын хэмжээнд тооцсон эзлэхүүн бүхий гадаргын ус цуглуулах сантай;

25.3.3.хүчтэй газар хөдлөлийн нөлөөллийг тооцож байгууламжийг барьсан;

25.3.4.хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах, тэсэрч дэлбэрэх, галын аюул үүсэх боломжийг хамгийн бага хэмжээнд байхаар төлөвлөж баригдсан;

25.3.5.зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал амьтан орохоос хамгаалсан хашаа, харуул хамгаалалттай, байгууламжийн орох, гарах хаалга болон дотор, гадна талбай, зам, устгалын үйл ажиллагааг тасралтгүй хянах хяналтын системтэй;

25.3.6.гадна болон дотор талбайд аюул, ослын үед ажиллах машин, техник, тоног төхөөрөмж ажиллах нөхцөлийг хангасан орц, гарц, замтай;

25.3.7.аюулгүй ажиллагааны болон аюул, ослын үед ажиллах дохиоллын систем, хариу арга хэмжээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, материалаар тоноглогдсон.

## **26 дугаар зүйл.Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх**

26.1.Энэ хуулийн 37.1-д заасан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхэлж, дараахь шаардлагын дагуу ажиллана.

26.1.1.аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанаас үүсэж болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байна.

26.1.2.орон нутгийн цагдаа, онцгой байдлын газар, эрүүл мэндийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.

26.1.3.ажилчдыг тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамруулна.

26.1.4.энэ хуулийн 26.1.3-т заасан сургалтад хамрагдаагүй ажилтныг бие даалган ажлын байранд ажиллуулахыг хориглоно.

26.1.5.аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна.

26.1.6.аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууламж нь онцгой байдлын зохицуулагчтай байна.

26.1.7.аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө хэрэгжүүлсэн тохиолдол бүрд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаархи тайланг аюул, осол гарснаас хойш 15 хоногийн дотор аймаг, нийслэлийн онцгой байдлын газар болон хог хаягдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

26.2.Аюултай эд анги агуулсан бүтээгдэхүүний хаягдал цуглуулах үйл ажиллагааг аюултай хог хаягдал хадгалах үйл ажиллагааны нэг хэлбэр гэж үзнэ.

26.3.Онцгой байдлын зохицуулагч аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрхтэй.

### **27 дугаар зүйл.Аюултай хог хаягдлыг хүлээн авах**

27.1.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хог хаягдлыг хүлээн авахын өмнө төлөөлөх дээжинд шинжилгээ хийж, шаардлагатай үзүүлэлтийг тодорхойлсон байна.

27.2.Аюултай хог хаягдлыг хүлээн авахдаа дагалдах бичигт заасан хог хаягдал мөн эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгаж авна.

27.3.Хог хаягдлын дагалдах бичиг, хог хаягдлын тоо хэмжээ, төрөлд үл зохицол илэрвэл хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээж авахаас татгалзаж болно.

27.4.Аюултай хог хаягдлыг савнаас суллахад энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг мөрдөнө.

### **28 дугаар зүйл.Үйл ажиллагааны бүртгэл хөтлөх**

28.1.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь дараахь мэдээллийг байгууламжийг хааснаас хойш 10 жил хадгална:

28.1.1.хүлээж авсан аюултай хог хаягдлын тодорхойлолт, тоо хэмжээ, түүнийг устгасан, боловсруулсан, хадгалсан арга, огноо;

28.1.2.байгууламжийн доторхи хог хаягдал нэг бүрийн байрлал, тоо хэмжээ, хог хаягдлын дагалдах бичгийн дугаар;

28.1.3.шинжилгээ, туршилтын дүн;

28.1.4.аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлсэн аюул, осол нэг бүрийн тайлан;



28.1.5. хяналт-шинжилгээний тайлан.

28.2. Энэ хуулийн 26.1.5-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тэмдэглэл, авсан арга хэмжээний тайланг гурван жил хадгална.

### **29 дүгээр зүйл. Тайлагнах**

29.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг энэ хуулийн 8.1.7.г-д заасан маягтаар гаргаж, энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хүргүүлнэ.

### **30 дугаар зүйл. Хяналт-шинжилгээ хийх**

30.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорхи ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байна.

30.2. Газрын доорхи усны хяналтын цооногоос авсан усны дээжин дэх бохирдуулагч бодисын хэмжээ нь стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

30.3. Байгууламжийг барьж байгуулахаас өмнө хийгдсэн судалгаа болон байгаль орчны суурь судалгааны хүрээнд итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр газрын доорхи усанд бохирдуулагч бодисын агууламж геологийн тогтоцоос хамаарч газрын доорхи усны стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс их байгаа нь тогтоогдвол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

30.4. Энэ хуулийн 30.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд газрын доорхи усны хяналт-шинжилгээнд мөрдөх зөвшөөрөгдөх дээд хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

30.5. Энэ хуулийн 30.1-д заасан хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээг хийнэ.

### **31 дүгээр зүйл. Байгууламжийг хаах**

31.1. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хаах хаалтын төлөвлөгөө, шаардагдах зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

31.2. Байгууламжийн технологи болон үйл ажиллагаанд өөрчлөлт гарсан тохиолдолд энэ хуулийн 31.1-д заасан төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулна.

31.3. Байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хаах тухай мэдэгдлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

болон аймаг, нийслэлийн Засаг даргад төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэхээс 90 хоногийн өмнө мэдэгдэнэ.

31.4.Байгууламжийг хэсэгчлэн болон бүрэн хаах хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

31.5.Сүүлчийн хаягдлыг хүлээж авснаас хойш 180 хоногийн дотор байгууламжийг бүрэн хаах хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусгана.

31.6.Байгууламжийг бүрэн хааснаас хойш 60 хоногийн дотор байгууламжийг хаасан мэдэгдэл, тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

## **32 дугаар зүйл.Хаалтын дараахь хяналт-шинжилгээ**

32.1.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь байгууламжийг хаасны дараа засвар үйлчилгээ хийх, хяналт тавих хаалтын дараахь хяналт-шинжилгээний төлөвлөгөө, шаардагдах зардлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

32.2.Хаалтын дараахь хяналт-шинжилгээг 20 жилийн турш хийнэ.

32.3.Энэ хуулийн 32.2-т заасан хяналт-шинжилгээг аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч эсхүл гэрээний үндсэн дээр хамтран гүйцэтгэгч хийнэ.

32.4.Энэ хуулийн 32.2-т заасан хяналт-шинжилгээгээр хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц хэмжээгээр шүүрэл, ялгарал үүсэж байгаа нь тогтоогдвол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.

32.5.Энэ хуулийн 32.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд холбогдон гарах зардлыг аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

32.6.Энэ хуулийн 30.1-д заасан хөтөлбөр, 31.1-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан зардлыг урьдчилан төлөх зарчмын дагуу дараахь хувилбарын аль нэгийг сонгож төвлөрүүлнэ:



- 32.7.1. итгэлцлийн сан байгуулах;
- 32.7.2. барьцаа хөрөнгө байршуулах.

32.8. Энэ хуулийн 32.7-д заасан хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

### **33 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага**

33.1. Аюултай хог хаягдлыг, хадгалж байгаа аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийсэн, эсхүл доторлосон бат бөх зориулалтын саванд хадгална.

33.2. Аюултай шингэн хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь асгарсан, алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадасыг тогтоон барих хязгаарлалтын системтэй байна.

33.3. Аюултай шингэн хаягдлыг газар доор суурилуулсан саванд хадгалахыг хориглоно.

33.4. Аюултай хуурай хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь хуримтлагдсан хур тунадасыг зайлуулах, шавхах боломжтой, сав нь хуримтлагдсан шингэнтэй хүрэлцэхгүй байхаар өргөгдсөн, эсвэл хамгаалагдсан байна.

33.5. Аюултай хог хаягдал хадгалах талбай нь хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байна.

33.6. Нийцгүй хог хаягдлыг нэг саванд хадгалахыг хориглоно.

### **34 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшилж устгахад тавигдах нэмэлт шаардлага**

34.1. Аюултай хог хаягдлын ландфилл нь хог хаягдал, түүнээс үүсэх шүүрлээс хөрс, газрын доорхи болон гадаргын ус бохирдохоос хамгаалах зориулалттай доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байна.

34.2. Аюултай хог хаягдлын ландфиллын доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах систем нь стандартад заасан шаардлагыг хангасан байна.

34.3. Шүүрлийн системд ердийн түвшинээс их шүүрэл ялгарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын удирдлага батална.

34.4.Энэ хуулийн 34.3-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлснээс хойш 30 хоногийн дотор цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг авсан арга хэмжээний тайлангийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.5.Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь булшилсан аюултай хог хаягдлын төрөл, нэг бүрийн байрлал, хэмжээ, гүнийг тэмдэглэсэн зураглал үйлдэж, аюултай хог хаягдлын бүтэц, байршлын талаар бүртгэл хөтөлнө.

34.6.Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хаахдаа батлагдсан зураг төслийн дагуу хучиж битүүмжлэх ба хучилтын давхарга нь стандартад заасан шаардлагыг хангасан байна.

34.7.Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь ландфиллыг бүрэн хаасны дараа энэ хуулийн 32.2-т заасан хяналт-шинжилгээ, арчилгаа үйлчилгээг авч хэрэгжүүлнэ.

34.8.Хаагдсан аюултай хог хаягдлын ландфиллын газар дээр аливаа үйл ажиллагаа эрхлэх, түүнийг ашиглахыг хориглоно.

34.9.Доорхи төрлийн хог хаягдлыг ландфиллд булшилж устгахыг хориглоно:

34.9.1.шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал;

34.9.2.хүн, малын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эмчилгээ, сувилгаанаас үүссэн, эрүүл мэндийн байгууллагаас халдваргүйжүүлээгүй хог хаягдал;

34.9.3.савлагаагүй шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал;

34.9.4.судалгаа, шинжилгээ, сургалтын явцад үүссэн, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл нь тогтоогдоогүй шинэ, эсвэл шинж чанар нь судлагдаагүй химийн бодисын хаягдал;

34.9.5.хоорондоо нийцгүй хог хаягдлыг нэг дор, нэг үүрэнд хамт булшлах.

34.10.Дараахь чөлөөт шингэн агуулсан савыг ландфиллд булшилж устгаж болно:

34.10.1.чөлөөт шингэнийг зайлуулсан, шингээгчид шингээсэн эсвэл хатууруулж бэхжүүлсэн;

34.10.2.тавин миллитрээс бага савлагаатай;



34.10.3. шингэн хадгалах зориулалтгүй, шингэн болон түүнийг агуулсан сав нь хамтдаа нэг зорилгоор ашиглагддаг батарей, аккумулятор зэрэг шингэн агуулсан сав;

34.10.4. нэг литрээс бага хэмжээтэй давхар савлагаатай шингэн.

34.11. Энэ хуулийн 34.10-т зааснаас бусад бүх төрлийн шингэнийг ландфиллд булшлахыг хориглоно.

34.12. Хоосон савыг ландфиллд булшлахад эзлэхүүний 90-ээс багагүй хувийг хогоор дүүргэж эсвэл жижиглэж, буталж эзлэхүүнийг нь багасгасны дараа булшилна.

34.13. Жижиг савлагаатай аюултай хог хаягдлыг (химийн бодис) зориулалтын саванд давхар савлаж, ландфиллд булшилж болох ба энэ хуулийн 7.1.2-т заасан журмын шаардлагыг хангасан байна.

### **35 дугаар зүйл. Аюултай хог хаягдал шатааж устгахад тавигдах нэмэлт шаардлага**

35.1. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэгч нь туршилтын шатаалт хийж, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлтийг тогтооно.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасан туршилтын шатаалтыг 30 хоног явуулах ба энэ хугацаанд шаталт тогтворжиж, шаардлагатай түвшинд хүрээгүй тохиолдолд хугацааг 30 хоног хүртэл хугацаагаар сунгаж болно.

35.3. Аюултай хог хаягдал шатаах зуух нь зуухны үйл ажиллагаа доголдох үед хог хаягдал ачаалах үйлдлийг зогсоох автомат системтэй байна.

35.4. Аюултай хог хаягдал шатаах зуух нь шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмжтэй байх ба уг төхөөрөмж нь энэ хуулийн 7.1.2-т заасан журмын шаардлагыг хангасан байна.

35.5. Зууханд өгөх хог хаягдлын ачаалалт болон зуухны бүтцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлт зөвшөөрөгдсөн хязгаараас давсан тохиолдолд зуухны үйл ажиллагааг зогсооно.

35.6. Шатаалтын зуух болон дагалдах тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд өдөрт нэгээс багагүй удаа хяналт тавина.

### **36 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг хянах системд тавигдах шаардлага**

36.1.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанаас агаарт ялгарах хий дэх бохирдуулагч бодисын хэмжээ нь стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан бохирдуулагч бодисын зөвшөөрөх хэмжээ үндэсний стандартаар тогтоогдоогүй бол олон улсын стандартыг мөрдөнө.

36.3.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламж нь агаарт ялгарах хийг хянах хяналтын систем, шингэн хаягдлыг цуглуулах, хуримтлуулах сантай байна.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан шингэнийг стандартаар зөвшөөрөгдсөн хэмжээнд хүртэл цэвэрлэх, саармагжуулж хаях, эсхүл аюултай шингэн хаягдал устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид өгч устгуулна.

36.5.Аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах байгууламжийн хий цэвэрлэх системээс үүссэн тоос, зуухны доод үнс зэрэг хатуу хаягдлыг зохих технологийн дагуу боловсруулж, аюултай хог хаягдлын ландфиллд булж устгана.

### **37 дугаар зүйл.Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл**

37.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.1-д заасан мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэхэд дараахь төрлийн зөвшөөрөл олгоно:

37.1.1.үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл;

37.1.2.үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.

37.2.Энэ хуулийн 37.1.1-д заасан зөвшөөрөл нь барилгын ажил эхлүүлэхээс үйл ажиллагаа эрхлэх хүртэлх хугацааг хамаарна.

37.3.Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа шинээр эхлүүлэхэд энэ хуулийн 37.1.2-т заасан зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгоно.

37.4.Энэ хуулийн 37.3-т заасан хугацаанд явуулсан үйл ажиллагаа, технологийн горим, хяналт-шинжилгээний дүнг үндэслэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаатайгаар олгоно.





37.5. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг арван жилийн хугацаагаар сунгана.

37.6. Зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

37.7. Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд дахин сэргээнэ.

37.8. Зөвшөөрлийг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

37.8.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

37.8.2. хуулийн этгээд татан буугдсан;

37.8.3. зөвшөөрлийг авахад хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

37.8.4. зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

37.8.5. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

37.9. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг мөрдөнө.

### **38 дугаар зүйл. Аюултай хог хаягдал экспортлох**

38.1. Аюултай хог хаягдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага экспортлож болно.

38.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аюултай хог хаягдал экспортлох зөвшөөрлийг доор дурдсан нөхцөлд олгоно:

38.2.1. аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах техник тоног төхөөрөмж байхгүй;

38.2.2. аюултай хог хаягдлын импорт тухайн улсад хүлээн зөвшөөрөгдсөн.

38.3. Аюултай хог хаягдлыг экспортлох этгээд нь зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

38.3.1. аюултай хог хаягдлыг импортлогч этгээдтэй байгуулсан гэрээ, импортлогч этгээдийн бичгээр гаргасан хүсэлт;

38.3.2.аюултай хог хаягдал импортлогч этгээдэд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;

38.3.3.аюултай хог хаягдлын тээвэрлэлт экспортлогч болон импортлогч улсаас өөр улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх бол тухайн орны эрх бүхий байгууллагаас нутаг дэвсгэрээрээ тээвэрлэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл, эсхүл мэдэгдэл.

38.4.Экспортлох аюултай хог хаягдал нь олон улсад мөрддөг заавар журам, стандартын дагуу савлагдсан, тэмдэг тэмдэглэгээ тавигдсан, хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлсэн байна.

38.5.Аюултай хог хаягдлыг тээвэрлэхдээ олон улсын гэрээ, конвенц, журамд заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

### **39 дүгээр зүйл.Аюултай хог хаягдал импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглох**

39.1.Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

39.2.Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хил дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

### **ХОГ ХАЯГДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **40 дүгээр зүйл.Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах**

40.1.Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.

40.2.Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дахивар нөөц сонгож, хаягдалгүй болон хамгийн бага хог хаягдал гаргах технологи ашиглана.

40.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжинэ.

40.4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно.



40.5.Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй.

40.6.Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх ба түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.

40.7.Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүн болон дахин боловсруулагдах хог хаягдал үүсгэх бүтээгдэхүүн нь энэ хуулийн 8.1.13-т заасан таних тэмдэгтэй байна.

40.8.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах байгууламж болон хог хаягдлын төвлөрсөн цэг, үйлдвэр технологийн паркийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд<sup>12</sup> заасны дагуу шийдвэрлэнэ.

#### **41 дүгээр зүйл.Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт**

41.1.Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.

41.2.Аюултай хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэсэн хог хаягдлаа тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгахтай холбогдон гарах зардалд шаардагдах аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс төлнө.

41.3.Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх, устгах үйлчилгээний хөлс нь энэ хуулийн 41.1-д заасан хураамжид хамаарахгүй.

41.4.Энэ хуулийн 41.2, 41.3-т заасан үйлчилгээний хөлсийг хог хаягдлыг хүлээн авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн дээр тохиролцон тогтооно.

41.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцно.

41.6.Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно.

<sup>12</sup> Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

41.7.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно.

41.8.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.

41.9.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:

41.9.1.хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх;

41.9.2.хог хаягдлыг булшлах;

41.9.3.энэ хуулийн 41.7-д заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх.

41.10.Хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.2.1-д заасан тарифыг үндэслэн цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

41.11.Хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг энэ хуулийн 9.1.4-д заасан тарифыг үндэслэн булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

41.12.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгаж зарцуулна.

41.13.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож сум, дүүргийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.

41.14.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлах үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүрэгт дэмжлэг үзүүлж болно.

41.15.Энэ хуулийн 41.14-т заасан дэмжлэгийг энэ хуулийн 41.9.1, 41.9.2-т заасны дагуу зарцуулна.

41.16.Хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанд улсын төсвөөс аймаг, нийслэлд дэмжлэг үзүүлж болно.



41.17.Энэ хуулийн 41.8-д заасан хөрөнгийг төлөвлөх, хянах, гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргах ажиллагааг Төсвийн тухай хууль<sup>13</sup>, Татварын ерөнхий хууль<sup>14</sup> тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХИ БОЛОВСРОЛ

#### 42 дугаар зүйл.Хог хаягдлын талаархи боловсрол олгох

42.1.Хог хаягдлын талаархи боловсрол нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаархи мэдлэг олгоход чиглэнэ.

42.2.Хог хаягдлын талаархи боловсролыг дараахь байдлаар олгоно:

42.2.1.энэ хуулийн 7.1.1-д заасан үндэсний хөтөлбөрт хог хаягдлын талаархи боловсрол олгох зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах;

42.2.2.хог хаягдлын талаархи албан боловсролыг энэ хуулийн 8.4.2-т заасан боловсролын агуулгаар дамжуулан олгох;

42.2.3.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаархи үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах;

42.2.4.албан бус боловсролыг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн сургалт, судалгааны төвөөр дамжуулан олгох.

42.3.Хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалтыг орон нутаг зохион байгуулж, иргэдийг сургалтад бүрэн хамруулахад бүх шатны Засаг дарга санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

42.4.Хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санаачлагаар хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт зохион байгуулахад сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга болон нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь сургалтын талбай, байраар дэмжлэг үзүүлэх, иргэдийн оролцоог хангахад туслалцаа үзүүлнэ.

<sup>13</sup> Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>14</sup> Татварын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



42.5.Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулах, сургалтын байр болон сургалтад шаардагдах бусад дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### БУСАД ЗҮЙЛ

#### **43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

43.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

43.1.1.энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.2.энэ хуулийн 8.2.1, 8.3.2, 8.5.1, 8.6.2, 9.1.3-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.3.энэ хуулийн 10.2.1, 10.2.4, 10.2.5, 10.2.7, 10.2.9, 10.2.10, 10.2.11-д заасныг зөрчсөн бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.4.энэ хуулийн 10.3.1, 10.3.2-т заасныг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.5.энэ хуулийн 10.3.3, 10.3.4-т заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.6.энэ хуулийн 10.3.5-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.7.энэ хуулийн 10.3.6-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.8.энэ хуулийн 10.3.7-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;



43.1.9.энэ хуулийн 14.4, 14.5, 14.6, 14.8-д заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.10.энэ хуулийн 14.3-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.11.энэ хуулийн 16.8-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.12.энэ хуулийн 18.1-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.13.энэ хуулийн 20.1, 20.2-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.14.энэ хуулийн 20.4-т заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.15.энэ хуулийн 24.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгох;

43.1.16.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.17.энэ хуулийн 26.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.18.энэ хуулийн 28.1-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.19.нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгжийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох;

43.1.20.энэ хуулийн 40.5-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг таван сая төгрөгөөр торгох;



43.1.21.энэ хуулийн 40.6-д заасныг зөрчсөн хүнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.22.энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталсан Хог хаягдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН  
ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “үүсэлтэй” гэсний дараа “болон хог хаягдал дахин боловсруулсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.31 дэх заалтын “оруулсан хандив, хөрөнгө” гэсний өмнө “болон хог хаягдлын боловсрол, сургалтыг дэмжихэд” гэж, мөн зүйлийн 12.1.35 дахь заалтын “агаарын бохирдлыг” гэсний дараа “болон хог хаягдлыг” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зар сурталчилгааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “үйлсийг” гэснийг “үйлс, иргэдэд хог хаягдлын талаар боловсрол олгохыг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.6 дахь заалт нэмсүгэй:

“4.1.6.хөг хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэх.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.1.Химийн хорт болон аюултай бодисын хаягдал устгах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эрдэнэт үйлдвэрийн хаалт, хотын хөгжлийн сан байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Туркменистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадамдоржийн Батхишигийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Туркменистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Грек Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхамсүрэнгийн Дүгэржавыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Грек Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашжамцын Батсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Саудын Арабын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Энхбатыг эгүүлэн татаж, Саудын Арабын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зоригтын Чинтүшигийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2017 оны 04 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Кипр Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхамсүрэнгийн Дүгэржавыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Кипр Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашжамцын Батсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2017 оны 04 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэдэнжавын Сүхбаатарыг эгүүлэн татаж, Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбын Ганхуягийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ****Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 4.75

**Индекс: 200003**